



МОНГОЛ УЛС  
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН  
ТОГТООЛ

2021 оны 06 сарын 23 өдөр

Дугаар 168

Улаанбаатар хот

Зөвшөөрөл олгох тухай

Төрийн албаны тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.4 дэх хэсэг, 65 дугаар зүйлийн 65.6 дахь хэсэг, Засгийн газрын 2019 оны “Төрийн захиргааны албан тушаалын ангилал, зэрэглэл, жагсаалт батлах тухай” 275 дугаар тогтоол, Засгийн газрын хэрэг эрхлэх газрын даргын 2021 оны “Үндэсний хөгжлийн газрын үйл ажиллагааны стратеги, бүтцийн өөрчлөлийн хөтөлбөрийг шинэчлэн батлах тухай” 23 дугаар тушаалыг тус тус үндэслэн Монгол Улсын Төрийн албаны зөвлөлөөс ТОГТООХ нь:

1.Засгийн газрын тохируулагч агентлаг- Үндэсний хөгжлийн газрын шинэчлэн батлагдсан үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтөд нийцүүлэн тус газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн даргын албан тушаалын тодорхойлолтыг 1 дүгээр, Судалгаа, шинжилгээний хэлтсийн даргын албан тушаалын тодорхойлолтыг 2 дугаар, Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн даргын албан тушаалын тодорхойлолтыг 3 дугаар, Хөрөнгө оруулалтын бодлого, төлөвлөлтийн хэлтсийн даргын албан тушаалын тодорхойлолтыг 4 дүгээр, Хяналт-шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын хэлтсийн даргын албан тушаалын тодорхойлолтыг 5 дугаар, Бүс, орон нутгийн хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн даргын албан тушаалын тодорхойлолтыг 6 дугаар, Хөрөнгө оруулалтын дэмжлэг, сурталчилгааны албаны даргын албан тушаалын тодорхойлолтыг 7 дугаар хавсралт ёсоор тус тус батлахыг Үндэсний хөгжлийн газрын дарга /Х.Батжаргал/-д зөвшөөрсүгэй.

2.Тогтоол батлагдсантай холбогдуулан Төрийн албаны зөвлөлийн 2020 оны 63 дугаар тогтоолын 1, 2, 3, 4, 5, 6, 8 дугаар хавсралтаар батлагдсан албан тушаалын тодорхойлолтыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

3.Хянаж зөвшөөрөл олгосон албан тушаалын тодорхойлолтыг албажуулах, баталж мөрдүүлэх, нэгдсэн санд бүртгэх үйл ажиллагааг мэргэшил, арга зүйн зөвлөгөөгөөр хангаж ажиллахыг Төрийн албаны зөвлөлийн Ажлын албанд даалгасугай.

ДАРГА

Б.БААТАРЗОРИГ



МОНГОЛ УЛС  
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН  
ТОГТООЛ

2021 оны 06 сарын 23 өдөр

Дугаар 169

Улаанбаатар хот

Зөвшөөрөл олгох тухай


Төрийн албаны тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.4 дэх хэсэг, 65 дугаар зүйлийн 65.6 дахь хэсэг, Засгийн газрын хэрэг эрхлэх газрын даргын 2021 оны “Үндэсний хөгжлийн газрын үйл ажиллагааны стратеги, бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг шинэчлэн батлах тухай” 23 дугаар тушаалыг тус тус үндэслэн Монгол Улсын Төрийн албаны зөвлөлөөс ТОГТООХ нь:

1.Засгийн газрын тохируулагч агентлаг-Үндэсний хөгжлийн газрын шинэчлэн батлагдсан үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтөд нийцүүлэн тус газрын Хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлт, тооцоо, судалгаа хариуцсан ахлах мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 1 дүгээр, Хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийн үйл ажиллагааг хариуцсан ахлах мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 2 дугаар, Хүний нөөцийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 3 дугаар, Хууль, эрхзүйн асуудал хариуцсан ахлах мэргэжилтний даргын албан тушаалын тодорхойлолтыг 4 дүгээр, Бүсчилсэн хөгжлийн удирдлага зохицуулалтын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, Үндэсний хорооны асуудал хариуцсан ахлах мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 5 дугаар, Бүс, орон нутгийн хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн ахлах мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 6 дугаар, Судалгаа, шинжилгээний хэлтсийн ахлах мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 7 дугаар, Хяналт-шинжилгээ, үнэлгээ дотоод, аудитын хэлтсийн ахлах мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 8 дугаар, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, тооцоо судалгаа хариуцсан мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 9 дүгээр, Хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлт, төсөл хариуцсан мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 10 дугаар, Хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлт, статистик, тоон мэдээ хариуцсан мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 11 дүгээр, Дотоод сүлжээ, мэдээллийн аюулгүй байдал хариуцсан мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 12 дугаар, Бүс, орон нутгийн хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 13 дугаар, Мэдээллийн систем, программ хангамж хариуцсан мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 14 дүгээр, Хуулийн асуудал хариуцсан мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 15 дугаар, Судалгаа, шинжилгээний хэлтсийн мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 16 дугаар, Хууль тогтоомжийн хэрэгжилт хариуцсан мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 17 дугаар, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Гадаадын зээл, тусламжийн хэрэгжилт хариуцсан мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 18 дугаар хавсралт ёсоор тус тус батлахыг Үндэсний хөгжлийн газрын дарга /Х.Батжаргал/-д зөвшөөрсүгэй.

2.Тогтоол батлагдсантай холбогдуулан Төрийн албаны зөвлөлийн 2020 оны 63 дугаар тогтоолын 9, 10, 11, 12, 13, 18, 19, 20, 21, 23, 24, 25, 26, 27, 28, 29, 33, 34 дүгээр хавсралтаар батлагдсан албан тушаалын тодорхойлолтыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

3.Хянаж зөвшөөрөл олгосон албан тушаалын тодорхойлолтыг албажуулах, баталж мөрдүүлэх, нэгдсэн санд бүртгэх үйл ажиллагааг мэргэшил, арга зүйн зөвлөгөөгөөр хангаж ажиллахыг Төрийн албаны зөвлөлийн Ажлын албанд даалгасугай.

ДАРГА

A square stamp with a faint background image of a building is overlaid with a large, bold, handwritten signature in black ink.

Б.БААТАРЗОРИГ



МОНГОЛ УЛС  
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН  
ТОГТООЛ

2021 оны 06 сарын 23 өдөр

Дугаар 120

Улаанбаатар хот

Тогтоолын хавсралтад өөрчлөлт  
оруулах тухай

Төрийн албаны тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.4 дэх хэсэг, 65 дугаар зүйлийн 65.6 дахь хэсэг, 66 дугаар зүйлийн 66.1.6 дахь заалт, Засгийн газрын хэрэг эрхлэх газрын даргын 2021 оны “Үндэсний хөгжлийн газрын үйл ажиллагааны стратеги, бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг шинэчлэн батлах тухай” 23 дугаар тушаалыг тус тус үндэслэн Монгол Улсын Төрийн албаны зөвлөлөөс ТОГТООХ нь:

Нэг.Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд оруулсан өөрчлөлтөд нийцүүлэн албан тушаалын тодорхойлолтод холбогдох өөрчлөлт оруулах саналыг дэмжсүгэй.

Хоёр.Төрийн албаны зөвлөлийн 2020 оны 63 дугаар тогтоолын зохих хавсралтад дараах өөрчлөлт оруулахыг Үндэсний хөгжлийн газрын дарга /Х.Батжаргал/-д зөвшөөрсүгэй.

**1/Тогтоолын 22 дугаар хавсралт:**

Хавсралтын “нэгжийн нэр” хэсгийн “Төрийн захиргааны удирдлагын газар” гэснийг “Төрийн захиргааны удирдлагын хэлтэс” гэж, “албан тушаалын нэр” хэсгийн “Гадаад харилцааны мэргэжилтэн” гэснийг “Гадаад харилцаа, хамтын ажиллагаа хариуцсан мэргэжилтэн” гэж, “Зорилт” хэсгийн “4.Байгууллагын болон нэгжийн дотоод үйл ажиллагаанд оролцох, тайлагнах” гэснийг “4.Нэгжийн үйл ажиллагаанд оролцож, удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг биелүүлэх, мэдээллээр хангах”, “5.Хууль тогтоомжоор хүлээсэн бусад чиг үүргийг хэрэгжүүлэх” гэж, “мэргэжил” хэсгийн “эрх зүй /042/” гэснийг “менежмент ба удирдахуй /041301-041303/” гэж тус тус өөрчлөх.

**2/Тогтоолын 14, 15, 30 дугаар хавсралт:**

Тогтоолын 14, 15, 30 дугаар хавсралтын “нэгжийн нэр” хэсгийн “Хөрөнгө оруулалтын бодлого, зохицуулалтын газар” гэснийг “Хөрөнгө оруулалтын бодлого, төлөвлөлтийн хэлтэс” гэж, “Зорилт” хэсгийн “4 дүгээр” зорилтыг “4.Нэгжийн үйл ажиллагаанд оролцож, удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг биелүүлэх, мэдээллээр хангах; 5.Хууль тогтоомжоор хүлээсэн бусад чиг үүргийг хэрэгжүүлэх” гэж өөрчлөн найруулах, 14 дүгээр хавсралтын “албан тушаалын нэр” хэсгийн “Олон улсын гэрээ, хэлэлцээр хариуцсан” гэснийг “Олон улсын гэрээ, конвенци, хамтын ажиллагааны асуудал хариуцсан” гэж, “зорилго” хэсгийн “хууль” гэсний өмнө “төрийн бодлого” гэж нэмэх, “мэргэжил” хэсэгт “эрх зүй /042/” гэж нэмэх, 15 дугаар хавсралтын “албан тушаалын нэр” хэсгийн “Хөрөнгө оруулалтын тухай хууль, бодлого, зохицуулалт, “Нэг цэгийн үйлчилгээний төв”-ийн үйл ажиллагаа хариуцсан” гэснийг “Хөрөнгө оруулалтын бодлого, төлөвлөлт, “Нэг цэгийн үйлчилгээний төв”-ийн үйл ажиллагаа хариуцсан” гэж тус тус өөрчлөх, “Зорилт” хэсгийн “2.Хөрөнгө оруулалтын гэрээ

байгуулахад оролцох, хянах, зохион байгуулах, Хөрөнгө оруулалт хийх зөвшөөрлийг гадаадын төрийн өмчит хуулийн этгээдэд олгох, шаардлага хангасан хөрөнгө оруулагч хуулийн этгээдэд тогтворжуулах гэрчилгээ олгоход хяналт тавих” гэснийг хасах, 30 дугаар хавсралтын “албан тушаалын нэр” хэсгийн “Хөрөнгө оруулалт бодлого, зохицуулалтын мэргэжилтэн” гэснийг “Хөрөнгө оруулалт бодлого, төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн” гэж өөрчлөх, “Зорилт” хэсгийн “Хөрөнгө оруулалтын гэрээ байгуулахад оролцох, хянах, зохион байгуулах” гэснийг хасах.

### **3/Тогтоолын 16, 31 дүгээр хавсралт:**

Хавсралтын “нэгжийн нэр” хэсгийн “хөрөнгө оруулалтын дэмжлэг, сурталчилгааны хэлтэс” гэснийг “хөрөнгө оруулалтын дэмжлэг, сурталчилгааны алба” гэж, 16 дугаар хавсралтын “зорилго” хэсэгт “Хөрөнгө оруулалтын талаарх төрийн бодлого, хууль тогтоомжийн биелэлтийг хангах,” гэж нэмэх, “Зорилт” хэсгийн “Хөрөнгө оруулалтын бодлого, хөрөнгө оруулалтад үзүүлэх дэмжлэг, арга хэмжээний талаар болон хөрөнгө оруулалтын тухай хуулийг боловсронгуй болгох талаар санал боловсруулах;” гэснийг “Хөрөнгө оруулалтын талаарх төрийн бодлого, хууль тогтоомж, шийдвэрийг хэрэгжүүлэх, эрхзүйн орчинг боловсронгуй болгох санал боловсруулах” гэж өөрчлөн найруулах, “4.Газрын өдөр тутмын үйл ажиллагааг тасралтгүй, хэвийн явуулахад газрын даргад дэмжлэг үзүүлэх, удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг биелүүлэх, биелэлтэд хяналт тавих, тайлагнах, Байгууллагын болон нэгжийн дотоод үйл ажиллагаанд оролцох, тайлагнах.” гэснийг “4.Нэгжийн үйл ажиллагаанд оролцож, удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг биелүүлэх, мэдээллээр хангах; 5.Хууль тогтоомжоор хүлээсэн бусад чиг үүргийг хэрэгжүүлэх” гэж өөрчлөх, 31 дүгээр хавсралтын “Зорилго” хэсгийн “Монгол Улсад хөрөнгө оруулалт татах үйл ажиллагааг хэрэгжүүлэх, хөрөнгө оруулалтын эрх зүйн орчин, дотоод зах зээлийн таатай нөхцөлийг хөрөнгө оруулагчдад сурталчлах, гүйцэтгэлийн үр дүнг газрын даргын өмнө хариуцна” гэснийг “Хөрөнгө оруулалтын тухай хууль тогтоомжийн биелэлтийг хангаж, Хөрөнгө оруулалтыг татах, хөрөнгө оруулалтын орчныг сурталчлах цогц үйл ажиллагааг хэрэгжүүлэх үндсэн үүргийг хүлээж, гүйцэтгэлийн үр дүнг хэлтсийн даргын өмнө хариуцна.” гэж, “Зорилт” хэсгийн “1.Хөрөнгө оруулалтын бодлого, хөрөнгө оруулалтад үзүүлэх дэмжлэг, арга хэмжээний талаар болон хөрөнгө оруулалтын тухай хуулийг боловсронгуй болгох талаар санал боловсруулах;” гэснийг “1.Хөрөнгө оруулалтын талаарх төрийн бодлого, хууль тогтоомж, шийдвэрийг хэрэгжүүлэх, эрхзүйн орчинг боловсронгуй болгох санал боловсруулах” гэж, “Байгууллагын болон нэгжийн дотоод үйл ажиллагаанд оролцох, тайлагнах.” гэснийг “4.Нэгжийн үйл ажиллагаанд оролцож, удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг биелүүлэх, мэдээллээр хангах; 5.Хууль тогтоомжоор хүлээсэн бусад чиг үүргийг хэрэгжүүлэх” гэж тус тус өөрчлөн найруулах, “2.Хөрөнгө оруулалтын тухай хууль тогтоомжийн биелэлтийг хангах” гэснийг хасах.

### **4/Тогтоолын 14, 15, 16, 22, 30, 31 дүгээр хавсралт:**

Тогтоолын 14, 15, 16, 22, 30, 31 дүгээр хавсралтын “зорилго” хэсгийн “газрын.” гэснийг “хэлтсийн” гэж, “туршлагын шаардлага” хэсгийн “Туслах түшмэлээс дээш ангиллын албан тушаалд 2-оос доошгүй жил ажиллаж байх” гэснийг “Туслах түшмэлийн албан тушаалд ажиллаж байсан бол давуу тал болно” гэж өөрчлөн найруулах, “Ур чадварын шаардлага” хэсгийн “бусад ур чадвар”-ын хэсгийн “албан хэрэг хөтлөх, баримт бичиг боловсруулах.” гэснийг “кирилл болон үндэсний бичгээр албан хэрэг хөтлөх чадвартай байх” гэж тус тус өөрчлөн найруулах.